

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 09 цаг 20 минутад эхэлж, мөн өдрийн 11 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 02 цаг 05 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн хэмжээнд 2020 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний төсөл хэлэлцэх тухай	1. Аймгийн хэмжээнд 2020 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний төсөл хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
2	Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолоор баталсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын тухай танилцуулга	1. Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоолоор баталсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яамдад хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Гомбосүрэн, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.
3	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга	1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, www.new.unelgee.gov.mn сайтад байршуулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Гомбосүрэн, тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
4	Сум байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамж, ажлын хэсгийн хуваарь танилцуулах тухай	1. Сум байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамж, ажлын хэсгийн хуваарийн дагуу хугацаанд нь чанартай хийж, дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг

		болгов.
5	Ховд аймаг-2019 Засаг даргын үйл ажиллагааны тайлангийн сэтгүүлийн тухай мэдээлэл	1.Ховд аймаг-2019 Засаг даргын үйл ажиллагааны тайлангийн сэтгүүлийг нэмж хэвлүүлэх тоо ширхэг, санхүүгийн эх үүсвэрийг судалж танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР